

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР



НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ

НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ЗААВАР

НЦУТ-ЕЗ-01:2023

*НЦУТ-ийн гэрчилгээний дугаар
№ 17401*

Байгууллагын хаяг

*Хаяг: 17120 Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа,
Шуудангийн салбар 34*

Утас: (976) 71285024

Факс: (976) 7004-9869

Цахим шуудан: amc@namem.gov.mn

Улаанбаатар хот

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАРЬЯА НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ


НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ЗААВАР ИНД-174

БАТЛАВ:
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
2022 оны 11 сарын 30 өдөр



Л.ОЮУНЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:
ИНЕГ-ЫН НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА
БӨГӨӨД НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
2023 оны 11 сарын 28 өдөр



П.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ИНЕГ-ЫН НААХЗА-НЫ АГААРЫН НАВИГАЦИЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ
2023 оны 11 сарын 24 өдөр



Д.МААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН
ТӨВИЙН ДАРГА
2023 оны 10 сарын 25 өдөр



Б.БАНЬДСҮРЭН

МЭДЭГДЭЛ

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэж буй нислэгт аюулгүй байдал хангасан цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээ, уур амьсгалын мэдээгээр үйлчлэх, мэдээлэл солилцох, хяналт тавих, зөвлөмж өгөх үндсэн чиглэлийн дагуу орон нутгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвүүдээс үзүүлж буй нисэхийн цаг уурын үйлчилгээг Нислэгийн цаг уурын төвд төвлөрүүлж, Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын стандарт, Иргэний нисэхийн дүрэм 174-ийн шаардлагад нийцүүлэн энэхүү “Ерөнхий заавар”-ыг боловсруулсан болно. Энэхүү **“Ерөнхий заавар”**-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын онцлогт тохирсон “Үйл ажиллагааны заавар”-ыг боловсруулан мөрдөж ажиллана.

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх нислэгт ДЦУБ-ын баримт бичгүүд, Чикагогийн конвенцын Хавсралт 3-т заагдсан стандарт шаардлагуудыг хангасан тоног төхөөрөмж, үйлчилгээг үзүүлнэ.

Нислэгийн цаг уурын төвийн зохион байгуулалтын бүтэц, удирдах албан тушаалтан, цаг уурын үйлчилгээний цар хүрээ, байгууллагын байрлал болон үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдөх тухай бүрд энэхүү зааварт өөрчлөлт оруулж холбогдох дүрмийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдэгдэж зөвшөөрөл авна.

Энэхүү зааврыг НЦУТ-ийн болон орон нутагт нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын албан хаагчид дагаж мөрдөнө.

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГА

Б.БАНЬДСҮРЭН

2021 оны 08 дугаар сарын 25

АГУУЛГА

1. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО	1
1.1 Аюулгүй байдлын бодлого	1
1.2 Аюулгүй байдлын зорилго.....	1
1.3 Аюулгүй байдлын зорилтууд	1
1.4 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөө	2
2. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	2
3. НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ	3
3.1 Төвийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явагдаж байгааг бататгах үүрэг бүхий албан тушаалтнууд:	3
3.2 Удирдах албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага:.....	3
3.3 Удирдах албан тушаалтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтэц.....	8
4. НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ	8
5. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИУЦЛАГЫН ШУГАМАН ХАМААРАЛ	9
6. ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГС ААЛТ	9
7. НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ЖАГС ААЛТ	10
7.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын байрлал.....	10
7.2 Тоног төхөөрөмжийн байрлал.....	11
7.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын цаг уурын үйлчилгээ,үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр, агаарын зай	12
8. ЦАГ УУРЫН МЭДЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ, ТҮҮНИЙ СТАНДАРТ ФОРМАТ	13
8.1 Цаг уурын мэдээний ангилал	13
8.2 Цаг уурын мэдээний стандарт болон формат	14
9. НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨГДӨХ ЖУРАМ, ТОГТОЛЦООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ	15
9.1 Албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшин.....	15
9.2 Ажиглалтын талбайд тавих шаардлага	15
9.3 Холбооны системийн шаардлага	16
9.4 Цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулах	16
9.5 Цаг уурын мэдээлэл боловсруулан гаргах	17
9.6 Тоног төхөөрөмжид тавих шаардлага.....	18
9.7 Баримт бичиг	19
9.8 Бататгах, хугацаат үзлэг шалгалт, тест тохируулга хийх.....	19
9.9 Цаг уурын мэдээлэл гаргах ба тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах	20

9.10	Цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдээлэх	22
9.11	Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах	22
9.12	Тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл	22
9.13	Бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах	23
10.	ЕРӨНХИЙ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ	23
10.1	Хяналт тавих	23
10.2	Нэмэлт, өөрчлөлт оруулах	23
10.3	Түгээх	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө
- Зураг 2. Бүтцийн шугаман хамаарал
- Зураг 3. Бүтцийн дэлгэрэнгүй
- Зураг 4. Аюулгүй байдлын шугаман хамаарал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Удирдах ажилтнуудын нэрс
- Хүснэгт 2. Удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын тодорхойлолт
- Хүснэгт 3. Хаяг байршил
- Хүснэгт 4. Нислэгийн цаг уурын төвийн тоног төхөөрөмж
- Хүснэгт 5. Орон нутгийн тоног төхөөрөмж
- Хүснэгт 6. Үйлчилгээний төрөл, нутаг дэвсгэр, агаарын зай
- Хүснэгт 7. “ОРМЕТ” мэдээг солилцох схем
- Хүснэгт 8. Уур амьсгалын мэдээ солилцох схем
- Хүснэгт 9. Мэдээ түгээх хуваарь

ЖУРАМ, ЗААВРЫН ЖАГСААЛТ

- Журам 1. Аюулгүй байдлын удирдлагын журам
- Журам 2. Онцгой тохиолдолд ажиллах журам
- Журам 3. Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам
- Журам 4. Дотоод аудитын журам
- Журам 5. Сургалтын журам
- Журам 6. Нислэгийн цаг уурын мэргэшлийн үнэмлэх олгох журам
- Журам 7. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам
- Журам 8. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийх журам
- Журам 9. Зайнаас тандан судлах төхөөрөмжийн журам
- Журам 10. Тоног төхөөрөмжийн журам
- Журам 11. Баримт бичгийн хяналтын журам
- Журам 12. Бүртгэл хяналтын журам
- Журам 13. Харьцуулсан ажиглалт хийх журам
- Журам 14. Үл тохирох бүтээгдэхүүний хяналтын журам
- Журам 15. Залруулах арга хэмжээний журам

Журам 16. Нислэгийн цаг агаарын таараагүй мэдээнд дүн шинжилгээ хийх журам

ЗААВАР 1. Гэмтэл дутагдлыг арилгах, шуурхай ажиллагааг хангах заавар

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ
НИСЛЭГТ ЦАГ АГААРЫН МЭДЭЭГЭЭР ҮЙЛЧЛЭХ, МЭДЭЭГ ХЭРЭГЛЭХ ТАЛААР
ХАМТРАН АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

ХҮЧИНТЭЙ ХУУДАСНЫ ЖАГСААЛТ (LIST OF EFFECTIVE PAGES)

№	Хэсэг	Хуудас	Хэвлэл, өөрчлөлт	Огноо
1	АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО	1	Хэвлэл 2	2023.10.24
2	НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ	3	Хэвлэл 2	2023.10.24
3	НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ	8	Хэвлэл 2	2023.10.24
4	АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИУЦЛАГЫН ШУГАМАН ХАМААРАЛ	9	Хэвлэл 2	2023.10.24
5	ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ	9	Хэвлэл 2	2023.10.24
6	НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	10	Хэвлэл 2	2023.10.24
7	ЦАГ УУРЫН МЭДЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ, ТҮҮНИЙ СТАНДАРТ ФОРМАТ	13	Хэвлэл 2	2023.10.24
8	НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨГДӨХ ЖУРАМ, ТОГТОЛЦООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ	15	Хэвлэл 2	2023.10.24
9	ЕРӨНХИЙ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ	23	Хэвлэл 2	2023.10.24

**НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН БҮРТГЭЛ
(TABLE OF NOTING CHANGES)**

№	Өөрчлөлт (Change number)	Өөрчлөлт оруулсан огноо (Inserted date)	Тайлбар (Comments)	Гарын үсэг (Signature)
1	2	3	4	5
1	Хэвлэл 01	2021.08.25	Анхны хувилбар	Б.Баньдсүрэн
2	Хэвлэл 01 Өөрчлөлт 01	2022.01.17	ИНД-174-ийн Зөвлөмжийн цуврал, нэр томьёоны тодорхойлолтын дагуу Цаг уурын үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт орсон (хуудас 14, 17, 25)	Б.Баньдсүрэн
3	Хэвлэл 01 Өөрчлөлт 02	2022.08.19	ЦУОШГ-ын даргын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан зохион байгуулалтын бүтцийн дагуу өөрчлөлт орсон	Б.Баньдсүрэн
4	Хэвлэл 02	2023.10.24	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх зорилгоор өөрчлөлт орсон	Б.Баньдсүрэн

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

ТҮГЭЭЛТ Distribution	Хэлтэс, алба Division name	Хяналтын дугаар	Хувь Version	Гарын үсэг Signature
	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс	01	2	
	Аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын хэсэг	02	1	
	Мэдээлэл, үйлчилгээний хэлтэс	03	2	
	Нислэгийн цаг уурын өртөө	04	2	
	Морин-Уул локатор, цаг уурын станц	05	1	
	ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба	06	1	
	Орон нутгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв	07	21	
	Ханбумбат, Тосонцэнгэл, Тавантолгой нисэх буудал	08	3	
	<i>Нийт Total</i>		33	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР (LIST OF ABBREVIATIONS)

ААЧХХ	- Аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын хэсэг
AFTN	- Нисэхийн цахилгаан холбоо
ДЦУБ	- Дэлхийн Цаг Уурын Байгууллага
ЗСААХ	- Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс
ИНБД	- Иргэний нисэхийн багц дүрэм
ИНД	- Иргэний нисэхийн дүрэм
ИНЕГ	- Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНУТ	- Иргэний нисэхийн үндэсний төв
НААХЗА	- Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба
НБ	- Нисэх буудал
НЦУТ	- Нислэгийн цаг уурын төв
НЦУУБ	- Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага (төв, орон нутгийн)
ОУДЦ	- Олон улсын дундаж цаг
ОУИНБ	- Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага
ОУНБ	- Олон улсын нисэх буудал
ОХЗЛ	- Оношилгоо хэмжил зүйн лаборатори
УЦУОШТ	- Ус цаг уур, орчны шинжилгээний төв
УЦУОСМХ	- Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
ХНАА	- Холбоо, навигац ажиллалтын алба
ЦУОШГ	- Цаг уур, орчны шинжилгээний газар

1. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

1.1 Аюулгүй байдлын бодлого

Агаарын навигацийн цаг уурын тасралтгүй хэвийн үйлчилгээг үзүүлж, хэмжлийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, нисэхийн аюулгүй байдлыг хангана. Үүнд:

- a) Аюулгүй байдлын гүйцэтгэлийн түвшнийг тасралтгүй дээшлүүлэх;
- b) Аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлж, хадгалахын тулд НЦУТ-ийн нийт албан хаагчдад сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол төлөвлөж, зохион байгуулах;
- c) ОУИНБ, ДЦУБ-ын стандарт, зөвлөмж болон үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг дагаж мөрдөх;
- d) Аюулгүй байдлыг хангасан үйлчилгээг хүргэхэд шаардлагатай нөөцөөр хангах;
- e) Аюулгүй байдлыг хангах нь бүх удирдах шатны албан хаагчдын үндсэн үүрэг байх;
- f) Төвийн нийт албан хаагчид нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, сайжруулах үйл ажиллагаанд оролцоотой байх;

1.2 Аюулгүй байдлын зорилго


НЦУТ нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд дараах зорилго зорилтыг тавьж ажиллана. Аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөгдөх түвшнийг Монгол Улсын хууль тогтоомж, ДЦУБ-ын болон ОУИНБ-ын баримт бичиг, ИНБД-ийн шаардлагад нийцүүлэн тодорхойлж хадгалах, үйл ажиллагааг байнга сайжруулснаар Олон улсын стандартад хүрсэн тогтолцоог бүрдүүлсэн байгууллага болох.

1.3 Аюулгүй байдлын зорилтууд

- 1.3.1 Аюулгүй байдлын ач холбогдлыг албан хаагч бүрд ухамсарлуулах, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор аюулгүй байдал, чанарын удирдлагын зөвлөлийг байгуулж, тэдгээрийг идэвх санаачилгатай ажиллах хөшүүрэг болох урамшууллын оновчтой системийг бий болгоно.
- 1.3.2 НЦУТ-ийн аюулгүй байдлын бодлого, зорилго зорилтуудын төвийн Аюулгүй байдал, дотоод сургалт, дотоод сүлжээ, төвийн цахим хуудас, ажлын байран дахь мэдээллийн самбар, зурагт хуудас гэх мэт ил тод байдлаар төвийн хэмжээнд нийт ажилтнуудад таниулж ойлгуулна.
- 1.3.3 Аюулгүй байдлыг үнэлэх, бататгах, сайжруулах, зорилгоор Lagging болон Leading аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (SPI) –ийн зорилтууд болон тэдгээрийн анхааруулах түвшнүүдийг тогтоон хэмжиж, хянадаг байна.
- 1.3.4 Аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилтууд:
 - a) SPI 1- “Агаарын хөлөг цаг агаарын мэдээлэл таараагүйгээс саатсан тохиолдол”-ыг 2023-2025 онуудад 0.44-өөс бууруулахгүй байх (Lagging Indicator)
 - b) SPI 2- Цаг уурын тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлын дунджийг 2023-2025 онуудад 95.0%-иас бууруулахгүй байх (Lagging Indicator)
 - c) SPI 3- Хөндлөнгийн хяналтын үл нийцэл, шаардлага, зөвлөмжийн тоог 2023-2025 онуудад 50-аас ихэсгэхгүй байх (Leading Indicator)
 - d) SPI 4- Аюулыг мэдээлэх хуудасны тоог 2023 онд 10 болгон цаашид 2025 он хүртэл жил бүр 5-аар нэмэгдүүлнэ (Leading Indicator)

- e) SPI 5- НЦҮҮБ-ын инженер, техникчдийн сургалт, дадлагын гүйцэтгэлийг 90%-иас бууруулахгүй байх (Leading Indicator)
 - f) SPI 6- Гаднын нөлөөллөөс шалтгаалсан сүлжээний гэмтэл дутагдлын тоог 2023 онд 30 болгон цаашид 2025 онд жил бүр 3-аар бууруулна (Leading Indicator)
- 1.3.5 Нийгмийн эрүүл мэнд, нийтийг хамарсан цар тахал үүсэх, гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга г.м байгалийн давтагдашгүй хүчин зүйл тохиолдохыг онцгой нөхцөл гэнэ.
- 1.3.6 1.3.5-д заасан онцгой нөхцөл байдлаас шалтгаалж нислэгийн саатал, осол, зөрчил гарах, цаг уурын сүлжээ, тоног төхөөрөмж доголдох, нислэгийг цаг агаарын мэдээллээр хангах хэвийн ажиллагаа алдагдах, доголдох зэргийг онцгой тохиолдол гэж үзнэ.

1.4 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөө



Зураг 1. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө

2. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

- 2.1.1 Аюулгүй байдлын удирдлагын үр нөлөөг хэмжих, бататгах үүднээс аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэмждэг байна.
- 2.1.2 Аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (SPI)-ийг ААЧХХ нь Аюулгүй байдал, чанарын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн тодорхойлж, аюулгүй байдлын зорилт, анхааруулах түвшнийг тогтооно.
- 2.1.3 Аюулгүй байдлын анхааруулах түвшнүүд нь SPI1-SPI3 аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн хувьд дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:
 - a) 1-р анхааруулах түвшин: Гүйцэтгэлийн үзүүлэлт нь зорилтот түвшнээс 0.05%-иар доошилсон.
 - b) 2-р анхааруулах түвшин: Гүйцэтгэлийн үзүүлэлт нь зорилтот түвшнээс 0.10%-иар доошилсон.

- с) 3-р анхааруулах түвшин: Гүйцэтгэлийн үзүүлэлт нь зорилтот түвшнээс 0.15%-иар доошилсон.
- 2.1.4 Хэлтэс, нэгжүүд нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг сар тутам тооцоолж, гүйцэтгэлийг ААЧХХ-т хүргүүлнэ.
- 2.1.5 Аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт нь мониторингийн явцад 1-р анхааруулах түвшнийг 3 удаа, 2-р анхааруулах түвшнийг 2 удаа хэмжиж буй хугацааны интервалд хэтэрсэн эсхүл 3-р анхааруулах түвшнийг 1 удаа давсан тохиолдолд төвийн удирдлага нь холбогдох арга хэмжээг яаралтай зохион байгуулж, авч хэрэгжүүлнэ.
- 2.1.6 ААЧХХ нь хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянаж, улирал тутам төвийн даргад танилцуулна.
- 2.1.7 Аюулгүй байдлын үзүүлэлт (SPI)-ийг шинэчлэх, шинээр бий болгох эсхүл хэрэглээг зогсоохдоо аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын хэсэг нь төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний онцлогийг харгалзан Аюулгүй байдал, чанарын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

3. НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ

Цаг уурын үйлчилгээ бүрийг санхүүжүүлэх, ИНД-174 дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэгдэж байгааг бататгах үүрэг бүхий Гүйцэтгэх захирал (цаашид төвийн дарга гэх)-ын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан:

Б.Баньдсүрэн: Нислэгийн цаг уурын төвийн дарга

3.1 Төвийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явагдаж байгааг бататгах үүрэг бүхий албан тушаалтнууд:

Хүснэгт 1. Удирдах ажилтнуудын нэрс

№	Нэр	Албан тушаал
1.	Б.Баньдсүрэн	Төвийн дарга
2.	Б.Болормаа	Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
3.	Б.Батцэцэг	Аюулгүй ажиллагаа, чанарын менежер
4.	Д.Баярмаа	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд хүний нөөцийн менежер
5.	Х.Тогтохгэрэл	Нислэгийн цаг уурын өртөөний дарга
6.	Х.Энхбаяр	Морин-Уул локатор, цаг уурын станцын дарга-инженер

3.2 Удирдах албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага:

Хүснэгт 2. Удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын тодорхойлолт

Албан тушаал	Үүрэг, хариуцлага
Төвийн дарга	<ul style="list-style-type: none"> - Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; - Байгууллагын төсөв, санхүүг хуулийн дагуу захиран зарцуулах; - НЦУТ-ийн үйл ажиллагааг Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хуулиуд бусад холбогдох хууль тогтоомж, Дэлхийн Цаг Уурын

	<p>Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын зөвлөмж, шаардлага, Иргэний нисэхийн дүрэм 174, зөвлөмжийн цувралын шаардлагын дагуу нисэхийн аюулгүй байдлыг хангасан цаг агаарын чанартай мэдээ, мэдээллээр шуурхай хангахад чиглүүлэх, нисэхийн цаг агаарын мэдээний хангалтын талаар гаргах шийдвэр, дүрэм, журам, зааврыг дангаараа буюу бусад байгууллагатай хамтран боловсруулж, холбогдох байгууллагуудаар батлуулан тэдгээрийг хэрэгжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;</p> <ul style="list-style-type: none"> - Нисэхийн цаг уурын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх, үр дүнг тооцох, гадаад дотоодын байгууллагатай хамтран ажиллах, тусгай хэрэгцээний мэдээгээр үйлчлэх, орон нутаг, байгууллагын тайланг үнэлэх; - Байгууллагыг төлөөлөн ИНЕГ, харилцагч байгууллагуудтай шууд харьцах; - Төвийн Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, хадгалах, сайжруулахад шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлж, хянаж нийт ажилтнуудыг зохион байгуулах; - Байгууллагын нэрийн өмнөөс шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх, аюулгүй байдлын асуудал, аюулгүй байдлын эрсдэлийг шийдвэрлэхийн тулд зохих арга хэмжээг авах, аюулгүй байдлын эрсдэлийн зөвшөөрөгдөх хязгаарыг тогтоох; - Ослын үед хариу арга хэмжээ авах; - Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой зөвлөмж шаардлагыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавина.
<p>Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хуулиуд бусад холбогдох хууль тогтоомж, Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын зөвлөмж, шаардлага, Иргэний нисэхийн дүрэм 174, зөвлөмжийн цувралыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах; - Нислэгт цаг агаарын мэдээ, мэдээллээр үйлчлэх, энэ ажлыг гүйцэтгэдэг байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах; - Нислэгийг цаг агаарын мэдээ, мэдээллээр үйлчлэх, ашиглахтай холбогдсон шийдвэр дүрэм, журам, зааврыг дангаараа буюу бусад байгууллагатай хамтран боловсруулж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх; - Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сайжруулах, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, арга боловсруулах ажлыг зохион байгуулах, үйлчилгээний ажлын шуурхай, тасралтгүй ажиллагааг хангах; - Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үйл ажиллагааны үл

	<p>тохирлыг залруулах, дахин давтагдахгүй байх арга хэмжээг зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дүгнэлт, зөвлөмж, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах; - Аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлэх; - Аюулгүй байдлын бодлогыг бий болгож, аюулгүй байдлын удирдлагатай холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Байгууллагын аюулгүй байдлын зорилтуудыг тодорхойлох; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах; - Мэргэшлийн шалгалтын тест боловсруулах, нууцлалыг хадгалах, шалгалт авах; - Монгол Улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэл, AIP болон NOTAM-аар зарлан мэдээлэгдэж буй нисэхийн өгөгдөл боловсруулах, цахимаар хянуулах, зарлуулах; - Төвийн даргын эзгүйд байгууллагыг төлөөлөн ИНЕГ, харилцагч байгууллагуудтай харьцах;
<p>Аюулгүй ажиллагаа, чанарын менежер</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хуулиуд бусад холбогдох хууль тогтоомж, Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын зөвлөмж, шаардлага, Иргэний нисэхийн дүрэм 174, зөвлөмжийн цувралын хэрэгжилтийн биелэлтэд хяналт хяналт тавих, шалгалт хийх; - Төв, орон нутгийн нисэхийн цаг уурын үйлчилгээний ажилд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг шалгалт хийж, залруулах, эрсдэлийг үнэлэх, зөвлөмж өгөх арга хэмжээ авч ажиллах; - Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дүрэм, журмын биелэлтэд байнгын хяналт, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх, үл тохирлыг илрүүлэх, сайжруулах, залруулах зорилгоор зөвлөмж боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөг удирдах; - Аюулыг тодорхойлох, аюулгүй байдлын эрсдэлд дүн шинжилгээ хийх; - Залруулах үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг нь үнэлэх; - Байгууллагын аюулгүй байдлын гүйцэтгэлийн тайлан гаргах; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баримт бичгийн бүртгэл хөтлөх; - Ажилтнуудын аюулгүй байдлын сургалтыг төлөвлөх, зохион байгуулах; - Аюулгүй байдлын асуудлаар бие даасан зөвлөгөө өгөх;

	<ul style="list-style-type: none"> - Нисэхийн салбарын аюулгүй байдлын асуудал, тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэхэд чиглэсэн байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хянах; - Аюулгүй байдалтай холбоотой асуудлаар бусад байгууллагуудтай харилцах; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлыг хариуцаж, удирдан зохион байгуулж, НЦУТ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж дүгнэлт зөвлөмж гаргах; - Мэргэшлийн шалгалтын тест боловсруулах, нууцлалыг хадгалах, шалгалт авах; - Монгол Улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэл, AIP болон NOTAM-аар зарлан мэдээлэгдэж буй нисэхийн өгөгдөл, мэдээллийн үнэн зөвийг хянан, цахимаар баталгаажуулах;
<p style="text-align: center;">Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд хүний нөөцийн менежер</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай хуулиуд, Иргэний нисэхийн дүрэм-174, Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын стандарт, шаардлага, Нислэгийн цаг уурын төвийн дүрэм, тэдгээрт нийцүүлсэн хэлтсийн үйл ажиллагаатай холбогдолтой журам, заавар ажлын технологийг мөрдлөг болгон ажиллах; - Чадварлаг ажилтныг бүрдүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх, шагнаж урамшуулах, идэвхжүүлэх, зохистой цалин хөлс тогтоох, албан тушаал дэвшүүлэх зэргээс гадна удирдлагын чиг үүргийн дагуу төлөвлөх, ажлын цагийн зохион байгуулалтын хэвийн хэмжээг мөрдөх, хянах; - Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, ажилтныг хөгжүүлж сургах, чиглүүлэх, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэл судалгааг хөтлөх, тайлагнах, нийгмийн даатгалд даатгуулах; - Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төвийн албан хаагчдын өдөр тутмын хөдөлмөрийн сахилга бат, ажлын үр дүн, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, тэдний мэргэжил, боловсролыг дээшлүүлэх талаар саналаа удирдлагад тавьж шийдвэрлүүлэх; - Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дүгнэлт, зөвлөмж, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах; - Аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлэх; - Аюулгүй байдлын бодлогыг бий болгож, аюулгүй байдлын удирдлагатай холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Байгууллагын аюулгүй байдлын зорилтуудыг тодорхойлох; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах; - Мэргэшлийн шалгалтын тестийн нууцлал, ашиглалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах;
<p style="text-align: center;">Нислэгийн цаг уурын</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай, Зөрчлийн тухай хуулиуд бусад

<p>өртөөний дарга</p>	<p>холбогдох хууль, тогтоомж, Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> - Өртөөний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, шинжилгээний ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шуурхай, тасралтгүй ажиллагааг хангах, нисэхийн цаг агаарын бодит мэдээний цувааны нэгэн төрлийн тасралтгүй байдалд хяналт тавих; - Өртөөний албан хаагчдын сахилга, дэг журамд хяналт тавих; - Хэрэглэгчдэд аюулгүй ажиллагааг хангасан цаг агаарын бодит мэдээгээр шуурхай үйлчлэх, хяналт тавих; - Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дүгнэлт, зөвлөмж, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах; - Аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлэх; - Аюулгүй байдлын бодлогыг бий болгож, аюулгүй байдлын удирдлагатай холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Байгууллагын аюулгүй байдлын зорилтуудыг тодорхойлох; - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах; - Мэргэшлийн шалгалтын тест боловсруулах, нууцлалыг хадгалах, шалгалт авах;
<p>Морин-Уул локатор, цаг уурын станцын дарга-инженер</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Иргэний нисэхийн тухай, Зөрчлийн тухай хуулиуд бусад холбогдох хууль, тогтоомж, Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах; Хэрэглэгчдэд нисэхийн аюулгүй байдал хангасан локаторын мэдээгээр шуурхай үйлчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих; - Станцын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, шуурхай, тасралтгүй ажиллагааг хангах; - Локатор болон цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажилд байнгын сайжруулалтын арга хэмжээ авч ажиллах, ажилтнуудын сахилга, дэг журамд хяналт тавих, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, дэвшилтэт техник, технологи судлах, ажилд нэвтрүүлэх талаар саналаа удирдлагад тавьж шийдвэрлүүлэх; - Чанарын удирдлагын тогтолцоо, Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дүгнэлт, зөвлөмж, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах; - Аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлэх; - Аюулгүй байдлын бодлогыг бий болгож, аюулгүй байдлын удирдлагатай холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Байгууллагын аюулгүй байдлын зорилтуудыг тодорхойлох;


	<ul style="list-style-type: none"> - Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах; - Мэргэшлийн шалгалтын тест боловсруулах, нууцлалыг хадгалах, шалгалт авах;
--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

3.3 Удирдах албан тушаалтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтэц




Зураг 2. Бүтцийн шугаман хамаарал

4. НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ



Зураг 3. Бүтцийн дэлгэрэнгүй

5. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИУЦЛАГЫН ШУГАМАН ХАМААРАЛ



Зураг 4. Аюулгүй байдлын шугаман хамаарал

6. ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

ДЦУБ, ОУИНБ-аас гаргасан заавар, журам зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэглэгчдэд цаг агаарын бүх төрлийн мэдээ, мэдээллээр тасралтгүй, шуурхай үйлчилгээ үзүүлэх.

Төвийн үйл ажиллагааны чиглэлүүд;

1. **Climatology service - Уур амьсгалын мэдээний үйлчилгээ**

Тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд зориулан уур амьсгалын мэдээ боловсруулах болон хангах үйлчилгээ;

2. **Forecast service - Урьдчилан мэдээлэх үйлчилгээ**

Тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан цаг уурын урьдчилсан мэдээллээр хангах үйлчилгээ;

3. **Information dissemination service - Мэдээлэл түгээх үйлчилгээ**

Цаг уурын мэдээллийг цуглуулах болон түгээх үйлчилгээ;

4. **Meteorological briefing service – Цаг уурын мэдээний зааварчилгаа өгөх үйлчилгээ**

Цаг уурын одоогийн болон таамаглаж байгаа нөхцөлийг бичгээр болон амаар тайлбарлан мэдээлэх үйлчилгээ;

5. **Meteorological reporting service - Цаг уурын мэдээний үйлчилгээ**

Цаг уурын тогтмол мэдээгээр хангах үйлчилгээ;

6. **Meteorological watch service - Цаг уурын ажиглалтын үйлчилгээ**

Тодорхой газар нутаг дахь агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд ажиглалт хийх үйлчилгээ;

7. НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

7.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын байрлал

Хүснэгт 3. Хаяг байршил

№	Байгууллагын нэр	Регистр	Байрлал	Холбоо барих утас
1.	Нислэгийн цаг уурын төв	9128794 /21/20070	Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа, 21-р хороо	71285024
2.	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	9005765	Баян-Өлгий аймаг, Өлгий сум 5-р баг	70422357
3.	Ховд аймгийн УЦУОШТ	9067671	Ховд аймаг, Жаргалант сум, Буянт баг	70432307
4.	Увс аймгийн УЦУОШТ	9062467	Увс аймаг, Улаангом сум, 5-р баг	70453680
5.	Завхан аймгийн УЦУОШТ	9039066	Завхан аймаг, Улиастай сум, Өлзийт баг	70462206
6.	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	9015833	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг	70484093
7.	Баянхонгор аймгийн УЦУОШТ	9007539	Баянхонгор аймаг, Баянхонгор сум	70442870
8.	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	9069917	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 6-р баг	70382351
9.	Дорнод аймгийн УЦУОШТ	9030905	Дорнод аймаг, Хэрлэн сум	70583087
10.	Өмнөговь аймгийн УЦУОШТ	9049681	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 6-р баг	70533648
11.	Булган аймгийн УЦУОШТ	9014128	Булган аймаг, Булган сум, 6-р баг	70342360
12.	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	3550192	Өвөрхангай-15160 Арвайхээр сум, 5-р баг	70322865
13.	Хэнтий аймгийн УЦУОШТ	4185471	Хэнтий аймаг, Хэрлэн сум	70562319
14.	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	9051503	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг	70518401
15.	Дундговь аймгийн УЦУОШТ	9033831	Дундговь аймаг, Сайнцагаан сум	70593093
16.	Архангай аймгийн УЦУОШТ	9003592	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 4-р баг	70332095
17.	Орхон аймгийн УЦУОШТ	9042466	Орхон аймаг. Баянцагаан баг. Тосгон	70355859
18.	Дархан-Уул аймгийн УЦУОШТ	9023291	Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р баг	70373783
19.	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	9057196	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 2-р баг	70362306
20.	Төв аймгийн УЦУОШТ	9060499	Төв аймаг, Зуунмод сум, 6-р баг	70273864
21.	Говьсүмбэр аймгийн УЦУОШТ	9018557	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг	70543166
22.	Дорноговь аймгийн УЦУОШТ	9025995	Дорноговь аймаг, Сайншанд сум, 6-р баг	70522771
23.	Тосонцэнгэл нисэх буудал	2628546	Завхан аймаг Тосонцэнгэл сум	71281186
24.	Ханбумбат нисэх буудал		Өмнөговь аймаг Ханбогд сум	71286136
25.	Тавантолгой нисэх буудал	3614476	Өмнөговь аймаг Цогтцэций сум	77222279

7.2 Тоног төхөөрөмжийн байрлал

Хүснэгт 4. Нислэгийн цаг уурын төвийн тоног төхөөрөмж

Нисэх буудлын нэр	Станцын нэр, Серийн дугаар	Станцын байрлал болон зайн хэмжилт	Станцын солбицол
Буянт-Ухаа ОУНБ (ZMUB)	Цаг уурын ажиглалтын автомат систем MILOS-520 S/N: Y274073	Зурвасын босго цэг 14 талаас 367.3 м, босго цэг 32 талаас 2732.7 м, ХБШЗ тэнхлэгээс 205 м	475033N 1064603E
	Цаг уурын нөөц автомат станц AWS 310	Зурвасын босго цэг 14 талаас 367.3 м, босго цэг 32 талаас 2732.7 м, ХБШЗ тэнхлэгээс 205 м	475033N 1064603E
	Хиймэл дагуулын мэдээлэл HimawariCast	НЦУТ-ийн төв байр	475033N 1064603E
	Радарын станц RC-53C	Цамхгаас баруун зүгт 4км-т Морин-Уул	482329N 1051027E
	Веб сервер Dell Precision T320	НЦУТ-ийн төв байр	475033N 1064603E
	Тоон загварын NWP сервер Dell Precision R930	НЦУТ-ийн төв байр	475033N 1064603E
	AFTN Terminal Dell Optiplex 360	НЦУТ-ийн төв байр	475033N 1064603E
Чингис хаан ОУНБ (ZMCK)	Цаг уурын ажиглалтын автомат систем MAWS 301	Төв аймаг, Сэргэлэн сум, Зуунмод хотоос 12км	475033N 1064603E
	Цаг уурын нөөц автомат станц AWS 330	Төв аймаг, Сэргэлэн сум, Зуунмод хотоос 12км	475033N 1064603E
	AFTN Terminal	Төв аймаг, Сэргэлэн сум, Зуунмод хотоос 12км	475033N 1064603E

Хүснэгт 5. Орон нутгийн тоног төхөөрөмж

№	Нисэх буудлын нэр	Станцын нэр, Серийн дугаар	Станцын байрлал болон зайн хэмжилт
1.	Ханбумбат НБ ZMKV	AWS-310 S/N: J35401	Зурвасын босго 15 талаас 2385.5 м, босго 33 талаас 864.5 м, явгалах замын тэнхлэгээс 267 м
2.		MAWS-301 S/N: J32401	Зурвасын босго 15 талаас 2947 м, босго 33 талаас 303 м, явгалах замын тэнхлэгээс 300 м
3.	Гурвансайхан НБ ZMDZ	MAWS-301 S/N:K1676478	Зурвасын босго 11 талаас 1542.6 м, босго 29 талаас 652.7 м, явгалах замын тэнхлэгээс 112.5 м
4.	Мандалговь НБ ZMMG	MAWS-301 S/N:K1676360	Зурвасын босго 18 талаас 122.7 м, босго 36 талаас 1627.3 м, явгалах замын тэнхлэгээс 107.6 м
5.	Өндөрхаан НБ ZMUN	MAWS-301 S/N:K0736179	Зурвасын босго 06 талаас 2217 м, босго 24 талаас 343 м, явгалах замын тэнхлэгээс 57 м
6.	Чойбалсан НБ ZMCD	AWS-330 S/N:H24405	Зурвасын босго 12 талаас 205.63 м, босго 30 талаас 2391.08 м, явгалах замын тэнхлэгээс 140.24 м
7.	Баруун-Урт НБ ZMBU	MAWS-301 S/N:K1676266	Зурвасын босго 18 талаас 112.7 м, босго 36 талаас 2246.6 м, явгалах замын тэнхлэгээс 79.4 м
8.	Булган НБ ZMBN	QLC-50 S/N:C22511	Зурвасын босго цэг 13 талаас 1518 м-т, босго цэг 31 талаас 403 м, явгалах замын эхлэлээс 130м
9.	Мөрөн НБ ZMMN	MAWS-301 S/N:K1676309	Зурвасын босго цэг 10 талаас 1062 м-т, босго цэг 30 талаас 1338 м, явгалах замын тэнхлэгээс 85 м

10.	Хархорин НБ ZMHN	QLC-50 S/N:V21405	Зурвасын босго цэг 01 талаас 895 м, босго цэг 19 талаас 995 м, явгалах замын тэнхлэгээс 57 м
11.	Өвөрхангай НБ ZMAN	QLC-50 S/N:S05507	Зурвасын босго цэг 14 талаас 207м, босго цэг 32 талаас 2467 м, явгалах замын эхлэлээс 75 м
12.	Баянхонгор НБ ZMBH	MAWS-301 S/N:K0736174	Зурвасын босго цэг 16 талаас 635 м, босго цэг 34 талаас 2636 м, явгалах замын тэнхлэгээс 85 м
13.	Отгонтэнгэр НБ ZMDN	MAWS-301 S/N:K234014	Зурвасын босго цэг 16 талаас 1300 м, босго цэг 34 талаас 1900 м, явгалах замын тэнхлэгээс 41м
14.	Тосонцэнгэл НБ ZMTL	QLC-50 S/N:S05519	Зурвасын босго цэг 10 талаас 400 м, босго цэг 28 талаас 2800 м, явгалах замын тэнхлэгээс 107 м
15.	Дэглий цагаан НБ ZMUG	MAWS-301 S/N:K1676442	Зурвасын босго цэг 13 талаас 1147.5 м, босго цэг 31 талаас 1550.1 м, явгалах замын тэнхлэгээс 94.3 м
16.	Өлгий НБ ZMUL	MAWS-301 S/N:K1676404	Зурвасын босго цэг 12 талаас 1241.9 м, босго цэг 30 талаас 1607.9 м, явгалах замын эхлэлээс 187.3 м
17.	Ховд НБ ZMKD	MAWS-301 S/N:K1676324	Зурвасын босго цэг 16 талаас 355.2 м, босго цэг 34 талаас 2494.2 м, явгалах замын тэнхлэгээс 147 м
18.	Ховдын Булган НБ ZMBS	QLC-50 S/N: S05503	Зурвасын босго цэг 17 талаас 591.5 м, босго цэг 35 талаас 1208.1 м, явгалах замын эхлэлээс 155.2 м
19.	Алтай НБ ZMAT	MAWS-301 S/N:K1676441	Зурвасын босго цэг 10 талаас 1069 м, босго цэг 28 талаас 1231 м, явгалах замын тэнхлэгээс 84.3 м
20.	Тавантолгой НБ ZMTT	AWS-330 S/N:H24201	Зурвасын босго цэг 16 талаас перпендикуляраар 1259.3м, босго цэг 33 талаас перпендикуляраар 1090.2 м, явгалах замын тэнхлэгээс 178.0 м

7.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын цаг уурын үйлчилгээ, үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр, агаарын зай

Хүснэгт 6. Үйлчилгээний төрөл, нутаг дэвсгэр, агаарын зай

№	Байгууллагын нэр	Нисэхийн цаг уурын үйл ажиллагааны төрөл		Үйлчилгээнд хамрагдах нутаг дэвсгэр	Агаарын зай
1.	Нислэгийн цаг уурын төв	6	C, F, D, B, R, W	Буянт-Ухаа, Чингис хаан ОУНБ, Тосонцэнгэл, Ханбумбат, Тавантолгой НБ, Улаанбаатар хот	ZMUB-C, ZMCK-C,
2.	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Өлгий НБ, Баян-Өлгий аймаг	D
3.	Ховд аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Ховд, Ховдын Булган НБ, Ховд аймаг	ZMKB-D, ZMBS-G
4.	Увс аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Дэглий цагаан НБ, Увс аймаг	D
5.	Завхан аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Отгонтэнгэр НБ, Завхан аймаг	G
6.	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Алтай НБ, Говь-Алтай аймаг	D
7.	Баянхонгор аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Баянхонгор НБ, Баянхонгор аймаг	G
8.	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Мөрөн, Хатгал НБ, Хөвсгөл аймаг	ZMMN-D, ZMHG-G
9.	Дорнод аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Чойбалсан НБ, Дорнод аймаг	D

10.	Өмнөговь аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Гурвансайхан НБ, Өмнөговь аймаг	D
11.	Булган аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Булган НБ, Булган аймаг	G
12.	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Арвайхээр, Хар хорин НБ, Өвөрхангай аймаг	G
13.	Хэнтий аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Өндөрхаан НБ, Хэнтий аймаг	G
14.	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Баруун-Урт НБ, Сүхбаатар аймаг	G
15.	Дундговь аймгийн УЦУОШТ	6	C, F, D, B, R, W	Мандалговь НБ, Дундговь аймаг	G
16.	Архангай аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Архангай аймаг	-
17.	Орхон аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Орхон аймаг	-
18.	Дархан-Уул аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Дархан-Уул аймаг	-
19.	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Сэлэнгэ аймаг	-
20.	Төв аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Төв аймаг	-
21.	Говьсүмбэр аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Говьсүмбэр аймаг	-
22.	Дорноговь аймгийн УЦУОШТ	4	F, D, B, W	Дорноговь аймаг	-
23.	Тосонцэнгэл нисэх буудал	5	D, R-Тосонцэнгэл НБ F, B, W - НЦУТ		G
24.	Ханбумбат нисэх буудал	5	D, R-Ханбумбат НБ F, B, W - НЦУТ		D
25.	Тавантолгой нисэх буудал	5	D, R-Тавантолгой НБ F, B, W - НЦУТ		G

8. ЦАГ УУРЫН МЭДЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ, ТҮҮНИЙ СТАНДАРТ ФОРМАТ

8.1 Цаг уурын мэдээний ангилал

Нисэхийн цаг агаарын бодит мэдээ (METAR, SPECI)

Нисэхийн үйл ажиллагааг цаг уурын мэдээгээр хангах зорилгоор тусгайлсан талбай, эсхүл агаарын зайн тодорхой хэсэгт хийсэн цаг агаарын үзэгдэл элементийн ажиглалтын мэдээ

Аэродромын урьдчилсан мэдээ (TAF)

Аэродром дээр тодорхой хугацааны турш цаг уурын нөхцөл байдлын ирээдүйн төлөв байдлын тухай мэдээ

SIGMET мэдээлэл (SIGMET information)

Өндрийн нислэгийн замын дагуух нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл ба агаар мандал дахь бусад үзэгдлүүд ажиглагдсан эсвэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед өгөх уг үзэгдлийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн тухай мэдээлэл

AIRMET мэдээлэл (AIRMET information)

Зөвхөн нам өндрийн нислэгт зориулсан нислэгийн замын дагуух цаг агаарын үзэгдэл, элементүүд ба тэдгээрийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн тухай мэдээлэл

Аэродромын сэрэмжлүүлэг мэдээ (Aerodrome warning)

Зогсоол дээр байгаа агаарын хөлөг болон аэродромын байгууламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болох цаг агаарын нөхцөл байдлын тухай товч мэдээ

Агаарын хөлгийн ажиглалтын (Aircraft observation)

Нисэж буй агаарын хөлгөөс хийсэн цаг уурын нэг буюу хэд хэдэн элементийн ажиглалт

Суултын урьдчилсан мэдээ (Landing forecast)

Тухайн аэродром дээрх цаг уурын нөхцөл байдалд үүсэж бий болох онцгой өөрчлөлтийн тухай товч мэдээлэл

Хөөрөлтийн урьдчилсан мэдээ (Take-off forecast)

Хөөрч, буух зурвас дээр тодорхой хугацааны турш бий болох урьдчилсан мэдээ

Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээ (Area forecast for low level flights)

Аэродромоос 50 км-ийн радиус доторх нам өндрийн нислэгт зориулсан урьдчилсан мэдээ

Чиглэлийн урьдчилсан мэдээ (Route forecast)

Аэродромоос нисэн гарах агаарын хөлөгт зориулсан урьдчилсан мэдээ

Өндрийн салхины урьдчилсан мэдээ (Upper wind forecast)

Нислэгийн мэдээллийн буюу удирдлагын бүсэд зориулсан урьдчилсан мэдээ

Угталтын урьдчилсан мэдээ (En-route forecast)

Урьдчилан мэдээлэх албагүй газраас ирэх нислэгт зориулсан нислэгийн замын дагуух цаг агаарын байдлын тухай урьдчилсан мэдээ

8.2 Цаг уурын мэдээний стандарт болон формат

Цаг уурын мэдээний стандарт болон форматыг ДЦУБ-ын цуврал №306 “Кодын гарын авлага” I боть, Чикагогийн конвенцын Хавсралт 3-т заагдсаны дагуу кодолж, түгээнэ.

Хүснэгт 7. “OPMET” мэдээг солилцох схем

Мэдээний төрөл		Схем
Нисэхийн цаг агаарын бодит мэдээ	METAR Мэдээ	SAMO31 CCCC ddhhmm (BBB)
	SPECI Мэдээ	SPMO31CCCC ddhhmm (BBB)
Аэродромын урьдчилсан мэдээ	TAF Мэдээ (9 цаг)	FCMO31 CCCC ddhhmm (BBB)
	TAF Мэдээ (30 цаг)	FTMO31 CCCC ddhhmm (BBB)
SIGMET мэдээ	Цаг агаарын аюултай үзэгдэл	WSMO31 CCCC ddhhmm (BBB)
	Галт уулын үнсний мэдээлэл	WVMO31 CCCC ddhhmm (BBB)
	Тропикийн циклоны мэдээлэл	WCMO31 CCCC ddhhmm (BBB)
AIRMET мэдээ	Нам өндрийн аюултай үзэгдэл	WAMO31 CCCC ddhhmm (BBB)
Аэродромын сэрэмжлүүлэг мэдээ	Цаг агаарын аюултай үзэгдэл	AD WRNG CCCC ddhhmm (BBB)
Агаарын хөлгийн ажиглалтын мэдээ	Нислэгийн явц дахь цаг агаарын аюултай үзэгдэл	UAMO61 CCCC ddhhmm (BBB)

Хүснэгт 8. Уур амьсгалын мэдээ солилцох схем

Мэдээний төрөл		Мэдээ дамжуулах толгой
Уур амьсгалын мэдээ	Үндсэн хугацааны мэдээ:	SMMO03 MNNI ddhhmm (BBB) AAXX ddhh0

		liii =
	Завсрын хугацааны мэдээ:	SIMO03 MNNI ddhhmm (BBB) AAXX ddhh0 liii =
	Аюул, Агаар мэдээ	AAMO03 MNNI ddhhmm AAMO liii..... =

Тайлбар: dd - мэдээ дамжуулсан өдөр, hh - дамжуулсан цаг (ОУДЦ), mm – минут

9. НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨГДӨХ ЖУРАМ, ТОГТОЛЦООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

9.1 Албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшин

- 9.1.1 Төвийн албан хаагчид нь тухайн албан тушаалд тохирох мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, тухайн албан тушаалын тодорхойлолтод нийцсэн байна.
- 9.1.2 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, ашиглах тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн түвшин ДЦУБ-ын цуврал №1083 “Ус, цаг уурын боловсрол, сургалтын стандартыг хэрэгжүүлэх заавар”, №1209 “ДЦУБ-ын боловсон хүчний мэдлэг, ур чадварын хураангуй”, ОУИНБ-ын цуврал №10 “Цаг уурын боловсон хүчний ур чадвар, мэргэшил”, НЦУТ-ийн “Сургалтын журам” зэрэг баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан байна.
- 9.1.3 Албан тушаалын тодорхойлолтыг ажлын байр болон албан тушаал тус бүрээр боловсруулж, төвийн даргаар баталгаажуулсан байна. Төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг ЦУОШГ-ын дарга баталгаажуулна.
- 9.1.4 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, түүнд хяналт тавих болон үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжийг ажиллуулах албан хаагчдыг ЦУОШГ-ын даргын 2022 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан “Нислэгийн цаг уурын мэргэшлийн үнэмлэх олгох” журмын дагуу үнэмлэхжүүлнэ.
- 9.1.5 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, ашиглах тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагчийг Стандарт, хэмжил зүйн газраас зохион байгуулдаг Ус цаг уур, орчны хэмжлийн багаж, төхөөрөмжийн шалгалт тохируулгын ажилтныг мэргэшүүлэх, эрх олгох сургалтад хамруулж, үнэмлэхжүүлнэ.
- 9.1.6 Мэргэжлийн ур чадварыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2023 оны А/421, А/115, А/170 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ын дагуу тогтооно.

9.2 Ажиглалтын талбайд тавих шаардлага

- 9.2.1 Ажлын байр болон тоног төхөөрөмжийг гаднын аливаа хууль бус халдлагаас сэргийлэх хамгаалалтын болон үйлчилгээг тасралтгүй явуулах зорилгоор ЦУОШГ болон ИНЕГ-ын хооронд байгуулсан “Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх талаар хамтран ажиллах ерөнхий гэрээ”-ний 2.11 дүгээр заалтын дагуу зохицуулна.
- 9.2.2 Цаг уурын тоног төхөөрөмжүүдийг Чикагогийн конвенцын Хавсралт 3, ДЦУБ-ын цуврал №08 “Ажиглалт хийх арга зүй ба тоног төхөөрөмжийн заавар”, “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам”-ын Appendix 3-т

заасны дагуу ажиглалтын талбайд байрлуулж, ЦУОШГ-ын даргын 2011 оны 149 тушаалаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийх журам”-ын дагуу хэмжих хэрэгсэлд засвар, шалгалт, тохиргоо, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийг хийж гүйцэтгүүлнэ.

- 9.2.3 Нисэх буудал дахь цаг уурын автомат станцад ИНЕГ-ын ОХЗЛ-иос холбогдох журмын дагуу шалгалт тохируулгын гэрчилгээ олгоно.
- 9.2.4 Үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардагдах цахилгаан эрчим хүч, газар ашиглалт, суурин утас, цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, дулааны эрчим хүчний гэрээг холбогдох эрх бүхий байгууллагуудтай байгуулж зохицуулна.
- 9.2.5 Цаг агаарыг зайнаас тандан судлах тоног төхөөрөмжийг төвийн даргын 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Зайнаас тандан судлах тоног төхөөрөмжийн журам”-аар зохицуулна.

9.3 Холбооны системийн шаардлага

- 9.3.1 ИНЕГ-ын нисэхийн цахилгаан холбоо (AFTN)-ны сүлжээгээр дамжуулж олон улс, орон нутгийн хэрэглэгч байгууллагуудтай цаг уурын мэдээ, мэдээллийг солилцоно.
- 9.3.2 ЦУОШГ-ын мэдээлэл дамжуулах сүлжээ (Message Switching System)-ээр дамжуулж олон улс буюу Новосибирск, Бээжингийн дата төв рүү мэдээлэл дамжуулна.
- 9.3.3 Шилэн кабелиар холбогдсон цаг уурын дотоод сүлжээгээр орон нутгийн НЦУҮБ-уудын цаг агаарын мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүлээн авч, дамжуулна.
- 9.3.4 Сүлжээний тоног төхөөрөмж, найдвартай ажиллагааг ханган ажиллана. Түүний найдвартай ажиллагааг бататгахын тулд тоног төхөөрөмжид үзлэг шалгалт, техник үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу үе шаттай шалгаж, найдвартай ажиллагаанд хяналт тавина. Үзлэг шалгалт техник үйлчилгээ хийгдсэн эсэхэд ААЧХХ-ээс хяналт тавина.
- 9.3.5 AFTN, AVIMET системийн хэвийн ажиллагаа алдагдсан үед ХНАА болон НЦУТ-ийн хамтран ажиллах гэрээний дагуу ХНАА-д, орон нутагт нисэх буудлын холбооны инженерт шуурхай мэдээлж, шийдвэрлүүлнэ.
- 9.3.6 Нисэхийн технологийн сүлжээний компьютерыг бусад хэрэглээнд ашиглах, зориулалтын бус программ хангамж суулгах, гаднын төхөөрөмж холбохыг хориглоно.
- 9.3.7 Холбооны системд тавигдах шаардлагыг Чикагогийн конвенцын Хавсралт 3 Appendix 10, ДЦУБ-ын цуврал №49 “ДЦУБ-Техникийн баримт бичиг “Олон улсын агаарын навигацийн үйлчилгээ дэх цаг уурын үйлчилгээ” Боть II-ын Бүлэг 11, “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам”-ын Appendix 10-ын дагуу зохицуулна.

9.4 Цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулах

- 9.4.1 Дараах мэдээний өгөгдлийг цуглуулан ашиглана. Үүнд:
 - а) Нислэгийн цаг уурын өртөө, НЦУҮБ болон нисэх буудлуудаас гэрчилгээжсэн цаг уурын бодит ажиглалтын систем, эсхүл станц ашиглаж гаргасан нисэхийн цаг агаарын болон уур амьсгалын бодит ажиглалтын мэдээ
 - б) Олон улсын нисэх буудлуудын нисэхийн цаг агаарын бодит ажиглалтын болон урьдчилсан мэдээ

- c) Дэлхийн болон бүсийн урьдчилан мэдээлэх төв (WAFS)-үүдээс гаргаж буй бүх төрлийн бүтээгдэхүүнүүд
 - d) Хиймэл дагуулын мэдээлэл (HIMAWARICAST)
 - e) НЦУТ, ЦУОШГ, УЦУОСМХ-ээс гаргаж буй бүх төрлийн мэдээ, мэдээлэл
 - f) Морин-Уул локатор, цаг уурын станцын үүл, хур тунадас, салхины мэдээлэл
 - g) Урьдчилсан мэдээ зохиоход ашиглаж болох интернэтэд суурилсан төрөл бүрийн тоон прогнозын үр дүн болон бүтээгдэхүүнүүд
 - h) Нислэгийн төлөвлөгөө
- 9.4.2 Цаг агаарын мэдээ, мэдээллийн өгөгдлийг дараах хаяг, суваг болон төхөөрөмжүүдийг ашиглан тогтоосон хуваарийн дагуу цуглуулна:
- a) НЦУУБ-үүдээс mnub@namhem.go.mn, <ftp://192.168.110.30/>,
<http://www.amc.namem.gov.mn> хаягаар,
 - b) Нисэхийн цахилгаан холбооны сүлжээ - AFTN:
“Буянт-Ухаа” ОУНБ ZMUBYMYX
“Чингис хаан” ОУНБ ZMCKYMYX
 - c) Телефон утаснууд:
“Буянт-Ухаа” ОУНБ 71283039, 71285023
“Чингис хаан” ОУНБ 71287279, 71287419, 91287279
Факс: 70049869
 - d) Цахим хуудас: <http://www.amc.namem.gov.mn>
 - e) Цахим шуудан: amc@namem.gov.mn
synoptic@mcaa.gov.mn
- 9.4.3 Цаг уурын мэдээний өгөгдлийг цуглуулахад тавигдах шаардлагыг НЦУУБ-уудын Үйл ажиллагааны зааварт тусгагдсан болно.

9.5 Цаг уурын мэдээлэл боловсруулан гаргах

9.5.1 Ангилал

Climatology service (C) - Уур амьсгалын мэдээний үйлчилгээ

- Уур амьсгалын тодорхойлолт
- Нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр зарлуулах мэдээлэл

Forecast service (F) - Урьдчилан мэдээлэх үйлчилгээ

- Урт, богино хугацааны
- Аэродром орчмын, нам, дунд, өндрийн

Information dissemination service (D) - Мэдээлэл түгээх үйлчилгээ

- Бодит мэдээ
- Урьдчилсан мэдээ

Meteorological briefing service (B) - Цаг уурын мэдээний зааварчилгаа өгөх үйлчилгээ

- Зурган мэдээлэл
- Дэлгэцээр
- Утсаар, цахимаар

Meteorological reporting service (R) – Цаг уурын мэдээний үйлчилгээ

- Нүдэн баримжаагаар
- Автомат багажаар

Meteorological watch service (W) – Цаг уурын ажиглалтын үйлчилгээ

- Аэродром орчмын цаг агаарын нөхцөл
- Нислэгийн зам дагуух цаг агаарын нөхцөл

- 9.5.2 Цаг уурын мэдээний стандарт болон формат нь Цаг уурын мэдээний стандарт болон форматыг ДЦУБ-ын цуврал №306 “Кодын гарын авлага” I боть,

Чикагогийн конвенцын Хавсралт 3, “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам” 1, 2-р дэвтэрт тусгагдсан болно.

9.6 Тоног төхөөрөмжид тавих шаардлага

9.6.1 Нисэхийн цаг уурын мэдээллийг олж авах, эмхэтгэх, тооцоолох, ашиглах эсхүл түгээхэд дараах тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Үүнд:

- a) Цаг уурын ажиглалтын автомат станц
 - Буянт-Ухаа ОУНБ MILOS 520 (үндсэн)
 - Буянт-Ухаа ОУНБ AWS 310 (нөөц)
 - Чингис хаан ОУНБ MAWS 301 (үндсэн)
 - Чингис хаан ОУНБ AWS 330 (нөөц)

9.6.2 Тус үндсэн болон нөөц станцуудаар агаарын температур, агаарын чийг, агаарын даралт, салхины хурд, чиглэл, хөөрч буух зурвасын дагуух алсын барааны харагдац (RVR)-ыг хэмжих бөгөөд мэдээллийг олж авах, эмхэтгэх, тооцоолох, ашиглах, түгээх зааврыг НЦУТ-АшЗ 012:2021, НЦУТ-АшЗ-005:2021, НЦУТ-АшЗ-013:2021, НЦУТ-АшЗ-002:2021-д тусгасан болно.

- b) Зайнаас тандан судлах тоног төхөөрөмж
 - Морин-Уул локаторын станц
 - HIMAWARI хиймэл дагуулын үүлний систем

Локаторын станц нь хэвтээ чиглэлд 480 км, босоо чиглэлд 16 км хүртэлх орон зайд үүлшил, тунадас, аянга цахилгаан болон тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлнэ. HIMAWARI хиймэл дагуулын үүлний систем нь хиймэл дагуулаас хүлээн авах антены тусламжтайгаар үүлний мэдээллийг хүлээн авч, боловсруулан зурган хэлбэрээр 10 минут тутамд шинэчлэгддэг. Зайнаас тандан судлах тоног төхөөрөмжүүдээр мэдээллийг олж авах, эмхэтгэх, тооцоолох, ашиглах, түгээх зааврыг НЦУТ-АшЗ-001:2021, НЦУТ-АшЗ-011:2021-т тусгасан болно.

- c) Цахим өгөгдөл боловсруулалтын сервер
 - Тоон загварчлал боловсруулалтын сервер NWP

Далай ба агаар мандлын судлалын үндэсний төв (NOAA) болон үндэсний цаг агаарын үйлчилгээний төв (NWS)-өөс эх мэдээг татан авч нислэгт зориулсан цаг агаарын тоон прогнозын боловсруулсан үр дүнг зураглах ажлыг 3 хүртэл домэйн (9 км, 3 км, 1 км) сонгон авч үр дүнгүүдийг 1 цагийн алхмаар бодуулан, аймаг хотууд болон нисэх буудал тус бүр зураглана. Нисэх буудал бүрийн хувьд загварын үр дүнгээр метеограммыг зураг болон текст хэлбэрээр гарган, үр дүнг 1–4 хүртэлх элементээр зураглан мэдээлэл дамжуулах системд нэмэлтээр оруулж төв болон орон нутгийн синоптик инженерүүд урьдчилсан мэдээ зохиолтод ашигладаг. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь 8 цаг тутамд автоматаар шинэчлэгдэнэ.

- d) Цахим мэдээлэл дамжуулах систем
 - Мэдээлэл дамжуулах систем MDS

Нисэхийн цаг уурын мэдээг интернэт болон дотоод сүлжээний орчинд хүлээн авч боловсруулах веб суурьтай программ хангамжаар төв, орон нутгийн синоптик инженерүүд, техникчид бодит болон урьдчилсан мэдээг дамжуулж, түгээнэ.

9.6.3 Цаг агаарын өгөгдлийг хүлээн авах, түгээхэд дараах сүлжээг ашиглана. Үүнд:

- a) Нисэхийн технологийн сүлжээ (AFTN, ATFMS, AWOS)
- b) Цаг уурын сүлжээ GTS (AWS, RADAR, NWP, MDS)

- 9.6.4 Нисэхийн цаг уурын үйлчилгээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмж болон зураг, мэдээ, бүтээгдэхүүнүүдийг Төвийн цахим хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд түгээж, нисэхийн үйлчилгээнд ашиглана.
- 9.6.5 Нисэхийн цаг агаарын мэдээний үйлчилгээнд шаардлагатай үндсэн цаг уурын автомат станцыг ЦУОШГ болон ИНЕГ-ын хооронд байгуулсан “Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх талаар хамтран ажиллах ерөнхий гэрээ”-ний 2.12 дугаар заалтаар ИНЕГ, нөөц станцыг тус гэрээний 3.16 дугаар заалтаар ЦУОШГ тус тус ханган, суурьлуулалт, ашиглалт, үйлчилгээг хариуцна.
- 9.6.6 ОУИНБ-ын баримт бичиг №9837 “Аэродром дэх цаг уурын автомат ажиглалтын системийн гарын авлага”, ДЦУБ-ын цуврал №08 “Ажиглалт хийх арга зүй ба тоног төхөөрөмжийн заавар”-т тусгагдсан шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжийг нисэхийн цаг уурын үйлчилгээнд ашиглана.
- 9.6.7 Цаг уурын автомат станцын мэдээллийн таарц нарийвчлал болон тухайн цаг хугацаандаа тохирсон эсэх, шинж чанар, бүтэц, хүчин чадлын талаар тус бүрийн батлагдсан ажиглалтын зааварт тусгасан байх бөгөөд бататгах журмуудыг ЦУОШГ-ын даргын 2011 оны 149 дүгээр тушаалаар батлагдсан “Ус, цаг уур орчны шинжилгээний хэмжих хэрэгсэлд засвар, баталгаажуулалт хийх журам”-ын дагуу хэмжих хэрэгсэлд засвар, шалгалт, тохиргоо, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийг хийж гүйцэтгүүлнэ.
- 9.6.8 Нисэх буудлууд нь ИНЕГ-ын ОХЗЛ-иос холбогдох журмын дагуу шалгалт тохируулга хийгдэж, гэрчилгээжсэн цаг уурын автомат станцыг ашиглана.
- 9.6.9 ИНД-172.55, 172.57-ын 5.7, 5.8, 5.12, 5.14 заалтад хамаарагдах цаг уурын хэмжих хэрэгслийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор үндсэн станцад гэмтэл саатал гарсан үед нөөц цаг уурын автомат станцыг ашиглана.

9.7 Баримт бичиг

- 9.7.1 Цаг уурын үйлчилгээг явуулахад шаардагдах заавар, журам, тоног төхөөрөмжийн гарын авлага, техник ажиглалтын зааварчилгаа болон бусад баримт бичгүүдийг үйл ажиллагаанд мөрдөх, хяналт тавихдаа төвийн даргын 2020 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичгийн хяналтын журам”, “Бүртгэл хяналтын журам”-ыг баримтална.

9.8 Бататгах, хугацаат үзлэг шалгалт, тест тохируулга хийх

- 9.8.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь цуглуулсан болон түгээж байгаа цаг уурын мэдээ бүрийг “Үйл ажиллагааны заавар”-т тусгасны дагуу бататгана.
- 9.8.2 Цаг уурын алба бүрд хугацаат үзлэг шалгалтыг хийхдээ төвийн даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын журам”-ыг баримтална.
- 9.8.3 Тоног төхөөрөмжийн бүрд хугацаат үзлэг шалгалт, тест тохируулгыг ДЦУБ-ын цуврал №08 “Ажиглалт хийх арга зүй ба тоног төхөөрөмжийн заавар”, ЦУОШГ-ын даргын 2011 оны 149 дүгээр тушаалаар батлагдсан “Ус, цаг уур орчны шинжилгээний хэмжих хэрэгсэлд засвар, баталгаажуулалт хийх журам”-ыг баримтална.
- 9.8.4 Нисэх буудал дахь цаг уурын автомат станцад ИНЕГ-ын ОХЗЛ-иос холбогдох журмын дагуу бататгах хугацаат үзлэг шалгалт, тест тохируулга хийнэ.
- 9.8.5 Хугацаат үзлэг шалгалтын календарьчилсан төлөвлөгөөг төвийн даргаар батлуулж, хуваарийн дагуу тоног төхөөрөмж хариуцсан ажилтан хийж гүйцэтгэнэ.

- 9.8.6 Цаг уурын үндсэн болон нөөц автомат станцыг хэвийн ажиллагааг бататгах зорилгоор төвийн даргын 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Харьцуулсан ажиглалт хийх журам”-ын дагуу сар бүрийн 15, 25-ны өдөр 30 минут тутмын 10 тоололтоор харьцуулан үнэн зөв байдлыг хянана.
- 9.8.7 Цаг уурын тандан мэдрэх тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг төвийн даргын 2020 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Зайнаас тандан судлах тоног төхөөрөмжийн журам”-ын дагуу зохицуулна.

9.9 Цаг уурын мэдээлэл гаргах ба тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах

- 9.9.1 Мэдээг бичих бүдүүвч болон дамжуулах цагийн хуваарийг чанд баримтална.
- Уур амьсгалын ажиглалтын мэдээг хоногт 8 удаа 15, 18, 21, 00, 03, 06, 09, 12 (ОУДЦ) цагуудад mhub@namhem.go.mn хаягаар дамжуулна.
 - Бодит мэдээний ажиглалт хийсний дараа METAR (SPECI) мэдээг 5 минутаас ихгүй хугацааны дотор багтаан дамжуулна.
 - Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ (FC)-г 1 цаг, урт хугацааны урьдчилсан мэдээ (FT)-г 1 цаг 30 минутаас багагүй хугацааны өмнө дараах хуваарийн дагуу зохион дамжуулна.

Хүснэгт 9. Мэдээ түгээх хуваарь

Хугацаа (ОУДЦ)	30 цагийн TAF		9 цагийн TAF	
	Үйлчлэх хугацаа	Мэдээ дамжуулах хугацаа (ОУДЦ)	Үйлчлэх хугацаа	Мэдээ дамжуулах хугацаа (ОУДЦ)
00	dd00/DD06	22.30	dd00/dd09	23.00
03			dd03/dd12	02.00
06	dd06/DD12	04.30	dd06/dd15	05.00
09			dd09/dd18	08.00
12	dd12/DD18	10.30	dd12/dd21	11.00
15			dd15/dd24	14.00
18	dd18/DD24	16.30	dd18/DD03	17.00
21			dd21/DD06	20.00

Тайлбар: dd - өмнөх өдөр, DD - дараах өдөр

- Богино хугацааны урьдчилсан мэдээг орон нутгийн нислэг эхэлснээс дуусах хүртэл хугацаанд зохиож дамжуулна.
- BBB – бүлэг нь мэдээнд нарийвчлал хийх, засвар оруулах, хугацаа хоцорсон эсэхийг илэрхийлнэ. Үүнд:
 - AAX** – Урьдчилсан мэдээ нарийвчилсан (**AMD**):
 - AAA** – Эхний нарийвчлал
 - AAB** – Хоёр дахь нарийвчлал
 - CCX** – Цаг агаарын мэдээ засварласан (**COR**):
 - CCA** – Эхний засвар
 - CCB** – Хоёр дахь засвар
 - RRX** – Цаг агаарын мэдээ хоцорсон:
 - Цаг агаарын бодит мэдээ хоцорсон
 - RRA**– 01 - 10 минут хоцроосон бол
 - RRB**– 11 - 20 минут хоцроосон бол
 - RRC** – 21 минутаас дээш хоцроосон бол
 - Цаг агаарын урьдчилсан мэдээ хоцорсон

RRA– 06 - 20минут хоцроосон бол

RRB– 21 - 40 минут хоцроосон бол

RRC – 41 минутаас дээш хоцроосон бол

9.9.2 Төвийн “Цахим хуудас”-т дараах мэдээллүүдийг тавина.

- a) Цахим мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах, хэрэглэгчдэд хандсан үйлчилгээ явуулахад зориулагдан хийгдсэн төвийн интернэт хуудас дээр мэдээлэл байршуулах тухай болон мэдээллийн байнгын тасралтгүй байдлыг хангах, хяналт тавихад чиглэгдсэн үйл ажиллагааг зохицуулна.
- b) Цахим хуудасны домэйн нэр нь буюу хандалт хийх хаяг нь <http://www.amc.namem.gov.mn> байна.

9.9.3 Төвийн цахим хуудас хуудсанд дараах мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулна:

- a) Байгууллагын танилцуулга
- b) Мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, заавар
- c) Санхүү, хүний нөөц, сургалт, үйл ажиллагааны ил тод байдал
- d) Төв болон орон нутгийн нисэхийн цаг агаарын бодит мэдээ
- e) Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ
- f) Чиглэлийн урьдчилсан мэдээ
- g) Хөөрөлтийн урьдчилсан мэдээ
- h) Өндрийн салхи, температурын урьдчилсан зураг мэдээ
- i) Хиймэл дагуулын мэдээлэл (HIMAWARI CAST)
- j) Морин-Уул локатор, цаг уурын станцын үүл, хур тунадас мэдээлэл
- k) Нисэхийн цаг уурын автомат станцын тухайн хугацааны бодит мэдээ (weather display)
- l) 7 хоног тутмын урьдчилсан мэдээ (нисэх буудал тус бүрээр)
- m) Сарын урьдчилсан мэдээ (ЦУОШГ)
- n) Цаг агаарын мэдээ, мэдээлэлтэй холбоотой зөвлөмж, гарын авлагууд
- o) Цаг үеийн мэдээ, мэдээлэл

9.9.4 Интернэтийн <http://119.40.103.9:8080>, <http://192.168.24.200:8080> хаягт Бүсчилсэн урьдчилсан мэдээний дэлхийн төв (WAFS)-өөс гаргаж буй стандарт төвшнүүд дэх салхи, температур болон онцгой үзэгдлийн зургуудыг тус тус байршуулна.

9.9.5 Цаг агаарын мэдээ боловсруулах үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжийг ажиллуулах, хариуцах албан хаагчдыг ажлын байранд ажиллах, мэргэшлийн үнэмлэх олгох сургалтад хамруулна.

9.9.6 Цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, ашиглах тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагчийг Стандарт, хэмжил зүйн газраас зохион байгуулдаг Ус цаг уур, орчны хэмжлийн багаж, төхөөрөмжийн шалгалт тохируулгын ажилтныг мэргэшүүлэх, эрх олгох сургалтад хамруулж, үнэмлэхжүүлнэ.

9.9.5 Эрх бүхий этгээдийн мэргэжлийн ур чадварыг хадгалахдаа өмнө олж авсан мэдлэг, ур чадвараа сэргээх, түвшин тогтоох, мэргэжлийг дээшлүүлэх, шинэ техник технологийг эзэмшихэд чиглэх, шинэ хэмжилт тохируулгын аргачлалыг сурах зэрэг чиглэлээр давтан сургалтад хамрагдаж, ажиллах эрхийг сунгана.

Цаг агаарын мэдээ боловсруулах үйлчилгээний тоног төхөөрөмжийг ашиглаж буй албан хаагчид нь сүлжээ, тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаанд хяналт тавьж, төхөөрөмжийн кабель утас салах, тэжээлийн кабель хөндийрөх, программ хангамж гацах зэрэг жижиг хэмжээний доголдлыг

оношилж, арга хэмжээ авах, бусад тохиолдолд тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагчид мэдэгдэнэ.

- 9.9.6 Тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах албан хаагч нь цаг агаарын мэдээ боловсруулах үйлчилгээнд ашиглах сүлжээ, тоног төхөөрөмжид үүссэн гэмтэл саатлын шалтгааныг нарийвчлан тогтоох, бүртгэх, арилгах арга хэмжээг шуурхай авах бөгөөд засагдах боломжгүй гэмтэл саатлыг төвийн даргад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.
- 9.9.7 Тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулахдаа НЦУТ-ийн даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Тоног төхөөрөмжийн журам”-аар зохицуулна.

9.10 Цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдээлэх

- 9.10.1 Цаг уурын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ, удирдах албан тушаалтнуудад өөрчлөлт орсон тохиолдолд ИНЕГ-ын НААХЗА-нд мэдэгдэнэ.
- 9.10.2 Агаарын навигацийн үйлчилгээнд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн ажиллагааны талаарх мэдээллийг ЦУОШГ, орон нутгийн УЦУОШТ-үүд, ИНЕГ-ын харьяа холбогдох алба салбар, албан тушаалтнуудад мэдээлнэ.
- 9.10.3 WAFS сервер ашиглалт түр хугацаагаар тасалдах, хэвийн болох
- 9.10.4 Веб сервер ашиглалт түр хугацаагаар тасалдах, хэвийн болох
- 9.10.5 Цаг уурын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар болон тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлын талаарх мэдээллийг Монгол улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэл (НМЭ)-д нийтлүүлсэн байна.
- 9.10.6 Энэхүү “Ерөнхий заавар”-т тусгагдсан үйл ажиллагаа, тоног төхөөрөмжид гарсан өөрчлөлт нь нисэхийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол энэ тухай харилцагч байгууллагууд болон ИНУТ-ийн НМҮА-нд шуурхай мэдэгдэж, NOTAM мэдээ зарлуулна.
- 9.10.7 Өөрчлөлт гарсан тухай мэдээллийг албан ёсоор харилцагч байгууллагууд болон НМҮА-нд хүргүүлэх бөгөөд уг ажлыг тухайн өөрчлөлт гарч буй холбогдох хэлтэс, нэгж хариуцсан албан тушаалтан нь хариуцан томилогдсон мэдээлэгчид хүргүүлнэ.
- 9.10.8 Томилогдсон мэдээлэгч нь НМҮА-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу НМЭ-д тусгагдсан цаг уурын үйлчилгээтэй холбоотой түр шинж чанартай NOTAM-аар зарлагдах өгөгдлүүд, түр шинж чанартай, шуурхай мэдээгээр зарлагдах өгөгдлүүдийг боловсруулан, ААЧХХ-ээр хянуулан, зарлуулна.
- 9.10.9 ААЧХХ нь томилогдсон мэдээлэгчээс ирүүлсэн мэдээллийг цахим хаягаар хүлээн авсан даруйд тухайн мэдээллийн дагуу холбогдох төв, орон нутгийн хэлтэс, нэгжээс үнэн зөвийг эх мэдээллээс магадлан шалгаж, баталгаажуулж мэдээлэгч рүү хариу хүргүүлж, бүртгэл хөтөлнө.

9.11 Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах

Энэхүү үйл явцыг төвийн даргын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам”-аар зохицуулна.

9.12 Тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл

Тоног төхөөрөмжийн доголдлыг төвийн даргын 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой тохиолдолд ажиллах журам”, 2021 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Гэмтэл дутагдлыг арилгах, шуурхай ажиллагааг хангах заавар”-аар, алдаатай мэдээллийг таньж тогтоох, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон

залруулах үйл ажиллагааг төвийн даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Үл тохирох бүтээгдэхүүний хяналтын журам”, “Залруулах арга хэмжээний журам”, “Нислэгийн цаг агаарын таараагүй мэдээнд дүн шинжилгээ хийх журам”, 2023 оны А/17 дугаар тушаалаар батлагдсан “Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны журам”-ын В бүлэг “Эрсдэлийн үнэлгээ хийх журам”-аар тус тус зохицуулна.

9.13 Бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах

9.13.1 НЦУҮБ-аас гаргаж, дамжуулж буй мэдээ мэдээллийг мэдээллийн сан үүсгэж, цаасан болон цахим хэлбэрээр “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг жил бүр шинэчлэн төвийн даргаар батлуулан хадгаламжийн нэгж үүсгэн архивд хадгална. (2021 оны “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”)

9.13.2 Бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах үйл ажиллагааг төвийн даргын 2020 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичгийн хяналтын журам”, 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Бүртгэл хяналтын журам”-аар тус тус зохицуулна.

10. ЕРӨНХИЙ ЗААВРЫГ ХЯНАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ТҮГЭЭХ

10.1 Хяналт тавих

10.1.1 Ерөнхий зааварт өдөр тутмын үйл ажиллагаа холбогдох журам, зааврууд, аюулгүй ажиллагааны шаардлагуудад нийцэж байгаа эсэхэд ААЧХХ байнгын хяналт тавьж ажиллана.

10.1.2 Ерөнхий зааврын хяналтыг ААЧХХ нь баримт бичгийн хяналт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийгддэг үзлэг шалгалт, төлөвлөгөөг үзлэг шалгалтаар гүйцэтгэнэ.

10.1.3 Ерөнхий зааврын хэрэгжилт, үл тохирлыг ААЧХХ хянахаас гадна төвийн хэлтэс, нэгж бүр өөрсдийн чиг үүрэгт хамааралтай журмуудын хэрэгжилт, үл тохиролд хяналт тавьж ажиллана.

10.2 Нэмэлт, өөрчлөлт оруулах

10.2.1 Дараах тохиолдлуудад Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлтүүдийг оруулна.
Үүнд:

- а) Холбогдох ИНД-үүдэд өөрчлөлт орсон;
- б) ЦУОШГ болон ИНЕГ-аас гаргасан НЦУҮБ-уудын үйл ажиллагаатай холбогдолтой заавар, журмуудад өөрчлөлт орсон;
- в) Аюулгүй байдалтай холбогдуулан НААХЗА-наас өөрчлөлт оруулахаар санал гаргасан;
- г) Ерөнхий заавар болон заавал мөрдөх шаардлагатай заавар, журмуудын хооронд үл тохирол үүссэн;
- д) Аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор НЦУҮБ-уудын өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага гарсан;
- е) Төвийн зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт орсон;
- ж) Төвийн удирдлага, салбар хариуцсан албан тушаалтанд өөрчлөлт орсон;
- з) Эрхэлж буй ажил, үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт орсон;

- i) Байгууллагын байрлал болон үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдсөн;
- 10.2.2 Албан хаагч нь Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй.
- 10.2.3 Санал гаргагч нь зааварт нэмэлт өөрчлөлт оруулах саналаа дэлгэрэнгүй тайлбарын хамт төвийн даргын зөвлөлд бичгээр гаргаж өгнө.
- 10.2.4 Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн холбогдох өөрчлөлтүүдийг Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд хүний нөөцийн менежер оруулна.
- 10.2.5 Зааварт нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж мөрдөж эхлэхээс 7 хоногийн өмнө төвийн салбар, хэлтсүүдэд мэдэгдэнэ.
- 10.2.6 Энэ журмын дагуу хийгдсэн аливаа өөрчлөлт нь “Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ”-нд өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол уг гэрчилгээнд өөрчлөлт оруулах саналыг ИНЕГ-т хүргүүлнэ.
- 10.2.7 Нэмэлт, өөрчлөлтийг дараах мэдээллийн дагуу оруулна:
 - a) Өөрчлөлтийн дугаар
 - b) Хүчин төгөлдөр болсон огноо
 - c) Өөрчлөлтийн агуулга
 - d) Өөрчлөлт оруулсан тухай
- 10.2.8 “Ерөнхий заавар”-ын өөрчлөлт орсон хуудас бүрд мөн хүчинтэй хуудасны жагсаалтад өөрчлөлтийн хүчин төгөлдөр болсон огноог тэмдэглэнэ.

10.3 Түгээх

Ерөнхий зааварт хийгдсэн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэлд оруулах ажлыг ЗСААХ гүйцэтгэнэ.

- 10.3.1 Ерөнхий зааврын нэмэлт, өөрчлөлтүүдийн дагуу холбогдох бусад бичиг баримтуудад өөрчлөлтүүд хийх ажлыг хэлтэс, нэгж хариуцсан албан тушаалтнууд хийнэ.
- 10.3.2 Батлагдан гарсан нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий зааврын хяналттай хувиуд байгаа хэлтэс, нэгжүүд болон холбогдох албан тушаалтанд бичгээр болон төвийн цахим хуудсаар ЗСААХ түгээнэ.